



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Гүйцэтгэлийн аудитын тайлан

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН
АЖИЛД ЧИГЛҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА**

**АУДИТЫН СЭДЭВ: “ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН
2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”**

2025 оны 05 дугаар сар

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ж.Айгүл

Утас: 70422954 Цахим хаяг: Aigulj@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Ахлах аудитор: У.Ербол

Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn

Аудитор: Ш.Нурлан

Утас: 99422966 Цахим хаяг: nurlansh@audit.gov.mn

Аудитор: Б.Үүрийнтуяа

Утас: 90832211 Цахим хаяг: uuriintuyab@audit.gov.mn

Аудитор: Ж.Назгүл

Утас: 99427301 Цахим хаяг: nazgulj@audit.gov.mn

2025 он

Товчилсон үгийн тайлбар	3
Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёг	4
Зургийн товъёг	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5
А.ЗУРАГ ТӨСӨВ, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТГҮЙ, ЭРЭМБЭЛЭГДЭЭГҮЙ ЗАРИМ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ТӨСВИЙН ТӨСӨЛД ОРУУЛЖ БАТАЛСАН БАЙНА	7
А.1. Хэрэгжүүлэхээр төлөвлсөн төсөл, арга хэмжээний 70 орчим хувь нь бага өртөг бүхий урсгал зардлын шинж чанартай төсөл арга хэмжээ байна	7
А.2. Зарим ТАХ-г зураг төсөв, техникийн тодорхойлолтгүй, эрэмбэлэгдээгүй байхад төлөвлөгөөнд оруулж баталсан байна	Error! Bookmark not defined.
Б.1. Тендер шалгаруулалтыг ил тод, нээлттэй зарлаж, хууль журмын хүрээнд ажиллаж байгаа боловч тендерийн маргаан тасрахгүй байна	10
В. ХЭРЭГЖИЖ ДУУССАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУД ӨМЧИЙН БҮРТГЭЛД ТУСГАСАН БОЛОВЧ САНХҮҮЖИЛТИЙГ БҮРЭН ОЛГООГҮЙ БАЙНА	16
В.1. Төсвийн төслийг үнэн зөв боловсруулах шаардлагатай байна	17
В.2. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бүрэн олгоогүй байна	17
В.3. Хэрэгжиж дууссан хөрөнгө оруулалтын ажлыг холбогдох байгууллагууд өмчийн бүртгэлд тусгасан байна	Error! Bookmark not defined.
ДҮГНЭЛТ:	20
Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:	20
ЗӨВЛӨМЖ:	20
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ САНАЛ:	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын Дээд байгууллагын Олон Улсын стандарт
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МАНУТХГ	Монгол Алтайн нурууны Улсын тусгай хамгаалалтын захиргаа
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ГА	Гүйцэтгэлийн аудит
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ТАХ	Төсөл арга хэмжээ
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХБТХОХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө	7
Хүснэгт 2	Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ төсөвт өртгөөр нь	8
Хүснэгт 3	ХАА-ын зохион байгуулалт	10
Хүснэгт 4	ТАХ-ний хэрэгжилтийн судалгаа	13

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Өлгий сумын 1-60 айлын орон сууцны гадна хүүхдийн тоглоомын талбайн ажил	13
Зураг 2	Ногооннуур сумын 4-р сургуулийн гал тогооны зуух	15
Зураг 3	“Үерийн далан барих” ажил	16

Хавсралтын жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Цахим дэлгүүрээс худалдан авалт хийсэн эсэх	11
Хавсралт 2	Захиалагчийн хяналтын судалгаа	16
Хавсралт 3	Зураг төсөв, зохиогч болон захиалагчийн хяналтын судалгаа	19

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлийн 9.1, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаал, Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 онд гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн үндэслэн гүйцэтгэв.
Аудитын зорилт	Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан дүнг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэв. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв.Үүнд: • Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээг холбогдох хуульд нийцүүлэн төлөвлөсөн эсэх • Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж, хүлээн авсан эсэх • Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний санхүүжилтийг шийдвэрлэж, хөрөнгө бүртгэлд тусгасан эсэх
Аудитын хамарсан хүрээ	Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитад аймгийн Засаг дарга түүний харьяа Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Барилга захиалагчийн алба болон холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хамруулан хийж гүйцэтгэв.
Аудитын хязгаарлалт	Цаг хугацааны хязгаарлагмал байдлаас шалтгаалан төсөл арга хэмжээний хэрэгжилтэд түүвэрлэн аудит хийж гүйцэтгэв.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах арга зүйг ашиглах зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, нотлох зүйл цуглуулж, ажлын баримт боловсруулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл хянан удирдаж, аудитын менежер Х.Женисбек чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор У.Ербол, аудитор Ш.Нурлан, Б.Үүрийнтуяа, Ж.Назгүл нар гүйцэтгэв.

Аудитын талбарын ажлыг 04 дүгээр сарын 28-наас 05 дугаар сарын 16-ны хооронд гүйцэтгэж, тайлагнах үе шатны ажлыг 05 дугаар сарын 16-наас эхлүүлж, 05 дугаар сарын 23-ны хооронд хийж гүйцэтгэв.

Хүндрэл бэрхшээл

Аудитыг богино хугацаанд хэрэгжүүлснээс зарим төсөл арга хэмжээний хэрэгжилтийг газар дээр нь үзэж шалгах боломж гараагүй болно.

А.ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ТӨСВИЙН ТӨСӨЛД ОРУУЛЖ БАТАЛСАН БАЙНА

А.1. Төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 68.8 хувь нь урсгал зардлын шинжтэй, төсөвт өртөг бага төсөл, арга хэмжээ байна

Баян-Өлгий аймгийн 2024 оны төсвийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 221 дүгээр тогтоолоор баталж, 2024 онд 2 удаа тодотгон баталсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд өмнөх оноос үргэлжлэн хэрэгжиж буй 949.4 сая төгрөгийн 10, шинээр эхлэх 10,547.6 сая төгрөгийн 176, нийт 10,547.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 186 ТАХ баталсан байна.

Хүснэгт №01. Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө

(сая төгрөг)

Ангилал	Шилжих		Шинээр эхлэх		Нийт		Хувь /Төсөвт өртгөөр/
	TAX	Төсөвт өртөг	TAX	Төсөвт өртөг	TAX	Төсөвт өртөг	
Барилга байгууламж			20	959.8	20	959.8	9.1%
Их засвар, тохижилт	10	949.4	82	3,754.9	92	4,704.3	44.6%
Тоног төхөөрөмж			66	3,468.5	6	3,468.5	32.9%
ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах			1	250.0	1	250.0	2.4%
Бусад			7	1,165.0	7	1,165.0	11.0%
Бүгд	10	949.4	176	9,598.2	186	10,547.6	100.0

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын 2024 оны 262 дугаар тогтоол

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын бүтцийг авч үзвэл нийт төсвийн 9.1 хувийг барилга, байгууламжийн 20, 44.6 хувийг их засвар, тохижилтын 92, 32.9 хувийг, тоног төхөөрөмжийн 6, 2.4 хувийг, ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах ажлын 1, 11.0 хувийг бусад төсөл, арга хэмжээний 7 төсөл, арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Барилга, байгууламжийн 959.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 20 төсөл, арга хэмжээний 40 хувийг гүний худаг гаргахад, 20 хувийг цахилгаан, халаалтын шугам татахад, 15 хувийг шилэн кабелд холбоход, 25 хувийг үерийн далан барих, нийтийн бие засах газар барих бусад төсөл, арга хэмжээнд хуваарилсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөвт өртгөөр нь авч үзвэл 68.8 хувийг 20.0 сая төгрөг хүртэлх 124 төсөл, арга хэмжээнд, 31.2 хувийг 20.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 56 төсөл, арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт №02. Төлөвлөсөн ТАХ төсөвт өртгөөр (сая төгрөг)

№	Төрөл	Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ		Хувь /ТАХ-ий тоогоор/
		TAX	Төсөвт өртөг	

1	Төсөвт өртөг нь 20.0 сая төгрөг хүртэлх ТАХ	124	2,087.2	69%
2	Төсөвт өртөг нь 20.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй ТАХ	56	7549.1	31%
	Нийт	180	9,636.3	100%

Эх сурвалж: Аудитын судалгаа

Дээрх хүснэгтүүдээс харахад төлөвлөсөн төсөл арга хэмжээний тоогоор авч үзэхэд 69.0 хувийг бага төсөвт өртөгтэй урсгал зардлын шинжтэй төсөл, арга хэмжээнд төлөвлөж батлуулсан нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг бүтээн байгуулалтын ажилд чиглүүлж төлөвлөөгүй байна.

Түүнчлэн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар чухал хэрэгцээ шаардлагатай эсэх нь тодорхой бус сургууль, цэцэрлэгүүдэд хатуу, зөөлөн эдлэл худалдан авахад 2,000.0 сая төгрөг, төрийн албан хаагчдыг компьютержуулахад 981.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ-г төлөвлөж батлуулсан нь үр өгөөжтэй хөрөнгө оруулалт болж чадаагүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тухайн онд төрийн байгууллагуудад тоног төхөөрөмж худалдан авахад 1,269.7 сая төгрөг, боловсролын салбарын байгууллагуудад тоног төхөөрөмж худалдан авахад 750.0 сая төгрөг, мөн боловсрол, хүүхэд хамгааллын салбарт тоног төхөөрөмж худалдан авахад 1,300.0 сая төгрөг төлөвлөж зарцуулсан нь улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт харилцан уялдаагүй, тооцоо судалгаагүй байгааг харуулж байна.

Тендер зохион байгуулахаас зайлсхийж, төсөл, арга хэмжээний зураг төсвийг баталсан төсөвт өртөгт тааруулж хийлгэдэг, гэрээ шууд байгуулах аргаар хэрэгжүүлэх зорилгоор төсөвт өртгийг жижиглэн олон ТАХ болгон төлөвлөдөг зөрчил давтагдаж байгаа явдалд дүгнэлт хийж, хөрөнгө оруулалтыг үр өгөөжтэй төсөл арга хэмжээнд төлөвлөхөд анхаарах шаардлагатай байна.

Хөрөнгө оруулалтыг тэргүүлэх ач холбогдолтой, зайлшгүй хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагатай, бүтээн байгуулалтын ажлуудад чиглүүлж төлөвлөж ажиллахыг аймгийн Засаг даргад зөвлөмж болгов.

Төсөвт өртөг нь 304.3 сая төгрөгийн үнийн дүнтэй Баяннуур сумын ахуй үйлчилгээний барилгыг цэцэрлэгийн зориулалттай болгон засварлах ажилд хөрөнгийн ашиглалттай холбоотой зардлыг төлөвлөж тусгаагүй байна. Бусад ТАХ-ний хувьд урсгал зардлын тооцоо хийгдэхээр ТАХ төлөвлөгдөөгүй, бага төсөвт өртөгтэй засварын ажлууд байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-г төлөвлөхдөө “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Баян-Өлгий аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” зэрэг аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн богино болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөсөн байна.

Харин тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжгүй, хөрөнгө оруулалтын бус шинж чанартай, урсгал зардлын 61.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Монголд зочлох жил" хөтөлбөрийг төлөвлөгөөнд тусгаж батлуулсан нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн

4.1.24¹, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6.2², Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3.2³ дахь заалтуудтай нийцэхгүй байна.

А.2. Зураг төсөв, техникийн тодорхойлолтгүй, эрэмбэлэгдээгүй ТАХ-г төлөвлөгөөнд оруулж баталсан байна

Аймгийн ИТХ-ын 2024 оны “Аймгийн 2024 оны төсвийн тодотгол батлах тухай” 262 дугаар тогтоолоор шинээр хэрэгжүүлэхээр 9,592.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 176 ТАХ баталсан байна.

Зураг төсөвгүй, техникийн тодорхойлолтгүй дараах 5 төсөл арга хэмжээг батлуулсан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁴, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-ийн 13.3.3⁵ дахь заалтад нийцэхгүй байна. Үүнд:

- Төв талбайн усан оргилуурын засвар 20.0 сая төгрөгийн,
- Бугат сумын гэрэлтүүлэгийн засварын ажил 15.0 сая төгрөгийн,
- Барилгын цэргийн 340 дүгээр ангид хөгжмийн зэмсэг 20.0 сая төгрөгийн,
- Мотоцикл худалдан авах 20.0 сая төгрөг,
- өгийн,
- Байгаль орчны нөхөн сэргээлтийн ажил 4.5 сая төгрөгийн, нийтдээ 79.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй.

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн дараахь 8 төсөл арга хэмжээг үнэлж эрэмбэлэгдээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29⁶.1 дэх заалт болон Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.3.1.1-т “*тухайн орон нутагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг холбогдох хууль, журам болон аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр үнэлэх, эрэмбэлэх*” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна. Үүнд:

- Төв талбайн усан оргилуурын засвар 20.0 сая төгрөгийн,
- Өлгий сумын 13 дугаар цэцэрлэгийн засвар 50.0 сая төгрөгийн,
- Бугат сумын гэрэлтүүлэгийн засварын ажил 15.0 сая төгрөгийн,
- “Монголд зочлох жил” хөтөлбөр 61.5 сая төгрөгийн,
- Байгаль орчны нөхөн сэргээлтийн ажил 4.5 сая төгрөгийн
- Дулааны 2 дахь эх үүсвэр болон түүний гадна шугам сүлжээний ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах ажил 250.0 сая төгрөгийн,

¹ Төсвийн хөрөнгө оруулалт гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг

² Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна.

³ хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ

⁴ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

⁵ техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ.

⁶ Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна

- Баяннуур сумын ЕБ-ын 1-р сургуулийн гал тогооны байрыг хөвгүүдийн дотуур байр болгон засварлах ажил 20.0 сая төгрөгийн,
- Сагсай сумын ЕБС-ийн 1 дүгээр сургуулийн хичээлийн байрны хаалга, цонх солих ажил 100.0 сая төгрөгийн, нийтдээ 521.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй.

Зураг төсөв нь хийгдээгүй, техникийн тодорхойлолтгүй, эрэмбэлэгдээгүй болон урсгал зардлын шинж чанартай, тухайн шатны төсвийн захирагчийн өмчлөлд шилжих боломжгүй ТАХ хөрөнгө оруулалтыг төлөвлөгөөнд тусгахгүй байхыг аймгийн Засаг даргад зөвлөмж болгов.

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар тухайн онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-г аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс хөрөнгө оруулалтын удирдлагын pimis.publicinvestment.gov.mn цахим системээр баталсан журам, аргачлалын дагуу үнэлж, эрэмблэн ажилласан байна.

Төлөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-г төлөвлөгөөнд оруулж батлуулсан нь аймгийн ИТХ-ын төлөөлөгчид болон удирдах албан тушаалтнуудын даалгавартай холбоотой боловч хөрөнгө оруулалт хариуцсан албан тушаалтан нарын ажилдаа хайнга хандсаныг харуулж байна.

Б. ЗАХИАЛАГЧИЙН ЗҮГЭЭС ХЯНАЛТЫГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

Б.1. Тендер шалгаруулалтай холбоотой маргаан давтагдаж гарсан байна

Аймгийн Засаг дарга Худалдан авах ажиллагааны газраас боловсруулж төлөвлөсөн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр баталсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар аймгийн хэмжээнд шинээр хэрэгжүүлэхээр 9,592.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 176 ТАХ төлөвлөгдсөнөөс тухайн онд аймгийн хэмжээнд 8,997.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 163 ТАХ-д худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна.

Аймгийн Засаг даргын 2024 оны А/01, А/640 дугаар захирамжуудаар 977.4 сая төгрөгийн 51 ТАХ-г холбогдох төсвийн захирагч нарт эрх шилжүүлсэн ба аймгийн ХААГ-аас 4,111.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ТАХ-д нээлттэй, 2,489.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 39 ТАХ-д харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Харин 1,119.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 64 ТАХ-д аймгийн Засаг дарга гэрээ шууд байгуулан хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт №03 Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт (сая төгрөг)

Тендер шалгаруулалтын арга	БӨ аймгийн ХААГазар (аймгийн Засаг дарга)		Бусад ТШЗ эрх шилжсэн		Нийт ХАА	
	ТАХ	Төсөвт өртөг	ТАХ	Төсөвт өртөг	ТАХ	Төсөвт өртөг
Нээлттэй	9	4,411.0			9	4,411.0
Харьцуулалт	39	2,489.6	2	141.0	41	2,630.6

ШХА	64	1,119.2	49	836.4	113	1,955.6
	112	8,019.8	51	977.4	163	8,997.2

Эх сурвалж: Аудитын судалгаа

Аймгийн хэмжээнд 4,411.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл, арга хэмжээг нээлттэй, 2,630.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 41 төсөл, арга хэмжээг харьцуулалтын аргаар, 1,955.6 төсөвт өртөгтэй 113 төсөл, арга хэмжээг гэрээ шууд байгуулах аргаар зохион байгуулсан байна.

Худалдан авах ажиллагааны 69.3 хувийг гэрээ шууд байгуулах аргаар хэрэгжүүлсэн төсөвт өртөг бага төсөл, арга хэмжээнүүд эзэлж байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн төсвийн байгууллагууд тоног төхөөрөмжийг (компьютер, принтер, ухаалаг дэлгэц, дүрс бичлэгийн камер г.м) цахим дэлгүүрээс худалдан авсан эсэхийг шалгахад 19 байгууллага 231.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг аж ахуйн нэгжүүдээс шууд худалдан авч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4⁷-т дахь заалтыг зөрчсөн байна. (Хавсралт №01-ээс дэлгэрэнгүй харна уу)

Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг зөвхөн цахим дэлгүүрээс авч, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах, зөрчил арилгах талаар аймгийн Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс албан шаардлага хүргүүлэв.

Аймгийн ХААГ-аас тухайн онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 6,900.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 48 төсөл, арга хэмжээний явцыг (төлөвлөлт, тендер шалгаруулалт, гэрээ) “tender.gov.mn” вэб сайтад ил тод мэдээлж, гүйцэтгэгч компаниудыг нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж ажилласан боловч тендертэй холбоотой маргаан жил болгон давтагдан гарч байна.

Аймгийн Худалдан авах ажиллагааны газраас тендер шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгосон 7 тендерийн ажлын бичиг баримттай холбоотой оролцогч компаниудаас Сангийн яаманд гомдол гаргасан байна.

Тендер шалгаруулалтад оролцсон компаниудаас гаргасан гомдлын дагуу тухайн тендер шалгаруулалтыг түдгэлзүүлж, аймгийн Засаг даргад 1,213.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ажлын тендерийг дахин хянан үзэж сонгон шалгаруулах мэдэгдэл хүргүүлж, 204.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ажлын тендерт оролцсон компанийн гаргасан гомдол үндэслэлгүй гэж үзэн өмнөх шалгаруулалтыг хууль тогтоомжид заасны дагуу цаашид үргэлжлүүлэхийг албан бичгээр мэдэгдсэн байна.

Гомдол гаргасан 7 худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалтыг ажил тус бүрээр авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

1. Төрөх тасгийн засварын ажлын тендертэй холбоотой “Өгөөж барс” ХХК-ны гаргасан гомдлын дагуу Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 03/2064 дугаартай албан бичгээр тендер шалгаруулалтыг түдгэлзүүлсэн. Тендерийг хороо 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр дахин хуралдаж шийдвэр гаргасан.

⁷ Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно.

2. Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн хичээлийн байрны хаалга, цонх солих засварын ажлын тендертэй холбоотой “Өгөөж барс” ХХК-ны гаргасан гомдлын дагуу Сангийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 03/3258 тоот албан бичигт “Эмпория” ХХК-ны ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын гэрээний үнийн дүнгийн мэдээлэл нь санхүүгийн тайлангийн мэдээллээс зөрүүтэй тул хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10-д заасны дагуу аймгийн Засаг даргын гэрээ байгуулах эрх олгосон албан бичгийг хүчингүй болгож тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг мэдэгдсэн.

Сонгон шалгаруулах үнэлгээний хороо нь үнэлгээг дахин хийж, “Өгөөж барс” ХХК-ыг шалгаруулж, гэрээ байгуулсан.

3. Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн дотуур байрны засварын ажлын Тендерийн хороо 4 компанийн тендер шалгаруулалтад ирүүлсэн баримт бичгийг шалгаж үзээд ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх заалтын дагуу бүх тендерээс татгалзаж дахин зарлахаар шийдвэрлэсэн.

“Досстрой” ХХК-ны уг шийдвэрийг эсэргүүцэж гаргасан гомдлыг Сангийн яам хянан үзэж, захиалагчийн шийдвэрийг хүчингүй болгосон. Үнэлгээний хороо дахин хуралдаж, “Досстрой” ХХК-тай гэрээ байгуулах шийдвэр гаргасан.

4. Аймгийн төвийн цэвэр усны станцад генератор худалдан авах ажлын тендертэй холбоотой “Баянхайрхан чоно” ХХК-ны гаргасан гомдлын дагуу Сангийн яам захиалагчийн шийдвэрийг үндэслэлгүй гэж үзэн тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг мэдэгдсэн. Үнэлгээний хороо дахин хуралдаж “Баян ангар” ХХК-ыг шалгаруулсан.

5. Өлгий сумын 13 дугаар цэцэрлэгийн засварын ажлын тендертэй холбоотой “Од дизайн” ХХК-ны гаргасан гомдлыг Сангийн яам хянаж гомдлын үндэслэлийг тодорхой заагаагүй тул хянан үзэх боломжгүй гэж үзсэн. “Интерренессанс” ХХК-нийн гомдлын дагуу хуульд нийцүүлэн дахин хийхийг мэдэгджээ. Үнэлгээний хороо нь дахин хуралдаж Сангийн яамнаас “Интерренессанс” ХХК-ний тендерийн бичиг баримт шаардлага хангаагүй гэж үзсэн тул уг тендерээс бүрэнд татгалзаж захиалагчаас дахин зарлах шийдвэр иртэл түр хугацаанд дахин зарлахгүй байхаар шийдвэр гаргаж дээрх ажил хийгдээгүй байна.

6. Аймгийн сургууль, цэцэрлэгүүдийн хатуу эдлэл худалдан авах ажлын тендертэй холбоотой “Ай Ел Нур” ХХК-ны гаргасан гомдлыг Сангийн яамнаас хуульд нийцүүлэн дахин хийхийг мэдэгдэж, тендерийн хороо дахин үнэлж “Ай Ел Нур” ХХК-ыг шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгосон.

7. Аймгийн сургууль, цэцэрлэгүүдийн зөөлөн эдлэл худалдан авах ажлын тендертэй холбоотой “Жансултан”-ны гаргасан гомдлын дагуу Сангийн яам түдгэлзүүлэн, тендерийн хороо дахин хуралдаж “Улыдала” ХХК-ний ирүүлсэн тендерийг шалгуур хангасан гэж үзэн, аймгийн Засаг даргад эрх олгох санал хүргүүлсэн.

“Баян ангар” ХХК Сангийн яаманд дахин гомдол гаргаж түдгэлзүүлсэн. Сангийн яам захиалагчийн гэрээр байгуулах эрх олгосон шийдвэрийг хүчингүй болгож хуульд нийцүүлэн дахин хийхийг албан албан бичгээр мэдэгджээ.

Үнэлгээний хороо тендерийн багц-3 буюу аймгийн төвийн 1-25 дугаар хүүхдийн цэцэрлэг, Хотгор багийн хүүхдийн цэцэрлэгийн зөөлөн эдлэл худалдаж авах тендерийг дахин шалгаруулан, “Баян ангар” ХХК-тай гэрээ байгуулах саналыг аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна.

Дээрх байдлаас дүгнэж үзэхэд аймгийн Худалдан авах ажиллагааны газраас тендер шалгаруулалттай холбоотой маргаан жил бүр давтагдан гарч буй байдалд дүгнэлт хийж, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд томилогдох АЗ сертификаттай албан тушаалтнуудыг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтыг тогтмол зохион байгуулах шаардлагатай байна.

Б.2. Төлөвлөсөн төсөл арга хэмжээний 87.6 хувь нь бүрэн хэрэгжсэн байна

Өмнөх оноос он дамжсан болон шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт 10,547.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 186 ТАХ-нээс 7,973.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 163 ТАХ бүрэн хэрэгжиж, 2,134.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 ТАХ-ний хэрэгжилт дутуу, 439.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 ТАХ хэрэгжээгүй байна. Хэрэгжилт дутуу ТАХ-ний 904.7 сая төгрөгийн 10 ТАХ нь дараа онд шилжих ТАХ байна.

Хүснэгт №04 ТАХ-ний хэрэгжилтийн судалгаа

(сая төгрөг)

Гүйцэтгэл	ТАХ	Төсөвт өртөг	Хувь /ТАХ-ний тоогоор/
Бүрэн хэрэгжсэн	163	7,973.5	87.6 %
Хэрэгжилт дутуу	13	2,134.6	7,0 %
Үүнээс: дараа онд шилжих	6	904.7	
Хэрэгжээгүй	10	439.5	5.0%
Нийт	186	10,547.6	100%

Эх сурвалж: Аудитын судалгаа

Аудитын явцад хэрэгжиж дууссан төсөл арга хэмжээг холбогдох зураг төсөв, техникийн шаардлагын дагуу хүлээн авсан эсэхийг шалгахад зөрчил илрээгүй, зохих үр дүнд хүрсэн байна.

Дараахь ТАХ-д төсөв хүрэлцээгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй, гүйцэтгэгч компани татгалзсан зэрэг шалтгаанаар хэрэгжээгүй байна. Үүнд:

- Төв талбайн усан оргилуурын засвар (Эрэмбэлэгдээгүй тул хэрэгжүүлэх боломжгүй болсон)
- Баяннуур сумын ЕБ-ын 1-р сургуулийн гал тогооны байрыг хөвгүүдийн дотуур байр болгон засварлах (2 удаа төлөвлөгөөнд орсон, төсөв хүрэлцээгүй тул хэрэгжүүлэх боломжгүй болсон)
- Өлгий сумын 13 дугаар цэцэрлэгийн засвар (төсөв хүрэлцээгүй тул хэрэгжүүлэх боломжгүй болсон)
- Бугат сумын гэрэлтүүлэгийн засварын ажил (төсөв хүрэлцээгүй тул хэрэгжүүлэх боломжгүй болсон)
- Барилгын цэргийн 340 дүгээр ангид хөгжмийн зэмсэг худалдан авах(төсөв хүрэлцээгүй тул хэрэгжүүлэх боломжгүй болсон)
- Баяннуур сумын 2 багийн салбар цэцэрлэгийн хатуу эдлэл худалдан авах (төсөв хүрэлцээгүй тул хэрэгжүүлэх боломжгүй болсон)

- Мотоцикл худалдан авах (Гүйцэтгэгч компани татгалзсан)
- Байгаль орчны нөхөн сэргээлтийн ажил (Гүйцэтгэгч компани татгалзсан)
- Дулааны 2 дахь эх үүсвэр болон түүний гадна шугам сүлжээний ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах төсөв хүрэлцээгүй тул хэрэгжүүлэх боломжгүй болсон

Харин хэрэгжилт дутуу дараах ТАХ-ний хувьд төлөвлөсөн хугацаанд дуусаагүй ба хүлээн авах боломжгүй байдал үүссэн байна.

- Өлгий сумын 1-60 айлын орон сууцны гадна хүүхдийн тоглоомын талбайн ажил нь тухайн үед техникийн нөхцөлийг бүрэн аваагүй, дэд бүтцийн шугамын дээр барилга байгууламж барьсан, оршин суучдаас гомдол гарсан тул хүлээн авах боломжгүй болсон.

Зураг №01 Өлгий сумын 1-60 айлын орон сууцны гадна хүүхдийн тоглоомын талбайн ажил



- Баяннуур сумын ахуй үйлчилгээний барилгыг цэцэрлэгийн зориулалттай болгон засварлах ажлыг барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гарсан боловч дэд бүтцийн (халаалт, цахилгаан, цэвэр бохир, усны шугам)-ын асуудлыг шийдэгдээгүйгээс аймгийн ОНӨГ орлого аваагүй, хариуцах эзэнгүй, үр дүнгүй, үр ашиггүй хөрөнгө оруулалт болсон байна
- Ногооннуур сумын ЕБ-ын 1-р сургуулийн дотуур байрны засварын ажлыг дуусгаж хүлээлгэж өгсөн боловч сольсон зарим хаалганууд нээж, хаахад бэрх, цоожнууд нь эвдэрсэн, зарим цонхнуудын шил хагарсан, цонхны тавцангуудыг 12-13 см дутуу тавцангаар сольж дутуу хэсэгт цементээр дүүргэсэн, гал тогооны дээвэрийг шинээр хийхдээ маш ниймгэн хийсэнээс болж хүйтэн ихээр алдаж өмнөхөөс хүйтэн болсон, хар цаасыг хуулж, дахин хийж өгөхөөр тохиролцсон боловч хийж өгөөгүй, дээврийн хонхор хэсгүүдийг тэгшилж цемент суутгаагүй, ус орох эрсдэлтэй байна. Засварын ажлыг ашиглалтад оруулах ажлын комиссын 2024.10.24-ний өдрийн хурлын тэмдэглэлээр дутуу ажлуудыг хийж гүйцэтгэх талаар тусгасан боловч тухайн өдөр комисс хүлээж авсан байна.
- 4 сумын айл өрхүүдийг шилэн кабельд холбох ажил нь гэрээний хугацаанд дуусаагүй.
- Өлгий сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн гадна хүүхдийн тоглоомын талбай барих ажил тухайн үед зураг төсөв бэлэн болоогүйн улмаас тендер хойшилж зарласнаас гэрээний хугацаанд дуусаагүй, хүйтэний улирал эхэлсэн тул зогсоож нэмэлт гэрээ байгуулсан.

- Өлгий сумын 10 дугаар багт цахилгаан татах ажлын тухайн үед зураг төсөв бэлэн болоогүйн улмаас тендер хойшилж зарласнаас гэрээний хугацаанд дуусаагүй
- Аймгийн төвийн айл өрхүүдийг шилэн кабельд холбох ажил мөн адил зураг төсөв бэлэн болоогүйн улмаас тендер хойшилж зарласнаас гэрээний хугацаанд дуусаагүй
- Дэлүүн сумын хуучин Эрүүл мэндийн төвийн засварын ажлыг гэрээнд заасан хугацаанд дуусгаагүй.

Ногооннуур сумын 4 дүгээр сургуулийн үдийн хоолны шинэ байрны халаалтын зуух худалдан авах гэрээний дүн 3.0 сая төгрөгийн ажлыг “Их түргэн Ачит” ХХК хийж гүйцэтгэж гал тогооны зуух нийлүүлж ажлын комисс хүлээн авсан байна

Зураг №02 Ногооннуур сумын 4-р сургуулийн гал тогооны зуух



Зах зээлд 300-400 м² талбайг халаадаг нам даралтын зуухны үнэ дунджаар 0.9-1.5 сая төгрөг байгаагаас харахад үнийн судалгаа хийгдээгүйг харуулж байна.

Аймгийн Онцгой комиссын 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 04 тэмдэглэлээр үерийн эрсдэлтэй бүс болох Өлгий сумын 2,3,12,13-р багуудын нутаг дэвсгэрийн 9 байршилд ус хурамтлуулах цооног, хайс хийх зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж гэрээ шууд байгуулахаар шийдвэрлэсэн боловч ОНХО-ын төсвөөс 80.0 сая төгрөг гаргахаар аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан байна.

“Үерийн далан барих” 80.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 144.0 сая төгрөгийн гэрээт ажлыг “Тэнэгэр алтан тоосго” ХХК гүйцэтгэн Өлгий сумын 2,3,12,13-р багийн нутаг дэвсгэрийн засмал замын дагуу 9 байршилд газар ухсан ажил хийгдсэн бөгөөд зураг төсвийн дагуу хийгдсэн эсэх нь эргэлзээтэй байна.

Зураг №02 “Үерийн далан барих” ажил



Өлгийн сумын нутаг дэвсгэрт өнгөрсөн жил хур бороо багатай байсан боловч аймгийн Онцгой комиссоос тендер зарлахгүйгээр гэрээ шууд байгуулах шийдвэр гаргаж, хэрэгжүүлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-ийн 35.1.2⁸-т дахь заалттай нийцэхгүй байна.

Барилга захиалагчийн албанаас тухайн онд барилга байгууламж, их засвар болон тохижилтийн 108 төсөл арга хэмжээнд хяналтыг хэрэгжүүлэхээс 92 төсөл арга хэмжээнд буюу 85.2 хувьд зохих хяналтыг хэрэгжүүлж, 16 төсөл арга хэмжээнд буюу 14.8%-д хяналт тавьж ажиллаагүй байна. **(Хавсралт 2-оос дэлгэрэнгүй харна уу)**

Аймгийн Засаг даргын шийдвэрээр төсөв захирагч нарт эрх шилжүүлсэн 19 төсөл арга хэмжээний хэрэгжилтэд ашиглагч байгууллагууд өөрсдөө хяналт тавьж, захиалагчийн зүгээс хяналт хэрэгжүүлээгүй байна.

Захиалагчийн зүгээс хяналт хэрэгжүүлээгүй ТАХ-г судалж үзэхэд аймгийн Засаг даргаас эрх шилжсэн хөрөнгө оруулалт байна.

Аудитаар гэрээнд заасан хугацаанд дуусгаагүй, удаашралтай ТАХ болон ашиглалтад авах боломжгүй болсон ТАХ-д дүгнэлт хийж шийдэрлэх, захиалагчийн хяналтыг сайжруулах талаар аймгийн Засаг даргад зөвлөмж болгов.

⁸ Онц байдал, гамшиг, ослын нөхцөл байдлын улмаас бий болсон хэрэгцээ, шаардлагыг даван туулахтай шууд холбогдох бараа, ажил, үйлчилгээг худалдан авах яаралтай хэрэгцээ бий болсон шалтгаанаар энэ хуульд заасан бусад аргаар тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй;

В. ОРОН НУТГИЙН ОРЛОГО БҮРДҮҮЛЭЛТТЭЙ ХОЛБООТОЙ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙГ БҮРЭН ОЛГООГҮЙ БАЙНА

В.1. Санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдуулж төлөвлөж, баталсан байна

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5-д “шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах”-аар заасан.

Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжих 10,547.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 9,432.5 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 186 ТАХ баталсан.

Аймгийн ИТХ-ын 2024 оны “Аймгийн 2024 оны төсвийн тодотгол батлах тухай” 262 дугаар тогтоолоор баталсан 185 ТАХ-ний санхүүжих дүнг 40.7-100.0 хувиар тусгасан байна.

Харин 250.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Дулааны 2 дахь эх үүсвэр болон түүний гадна шугам сүлжээний ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах” ажлын тухайн онд санхүүжих дүнг 14 хувиар баталсан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5⁹-д заасан шалгуурыг хангаагүй байна.

Дээрх төсөл нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй, зураг төсөв бэлэн болоогүй, нийт дүнгээр төсөвт тусгаж баталсан ТАХ тул хэрэгжээгүй байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 262 дугаар тогтоолоор баталсан тодотголоор өмнөх оноос үргэжлүүлэн хэрэгжиж байгаа 949.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 450.5 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 9 ТАХ тусгасан боловч МСҮТ-ийн дотуур байрны засварын ажлыг (Төсөвт өртөг нь 102.1 сая төгрөг, гэрээний дүн нь 97.1 сая төгрөг, тухайн онд санхүүжих дүн нь 10.3 сая төгрөг) орхигдуулсан байна.

Төсвийн төсөл боловсруулахдаа төсөвт өртөг 304.3 сая төгрөг Баяннуур сумын ахуй үйлчилгээний барилгыг цэцэрлэгийн зориулалттай болгон засварлах” ажил, төсөвт өртөг нь 20.0 сая төгрөг “Баяннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн гал тогооны байрыг хөвгүүдийн дотуур байр болгон засварлах” төсөвт өртгийг 2 удаа баталсан байна.

В.2. Төсөл арга хэмжээний санхүүжилтийн 84.7 хувийг олгосон байна

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй 9,618.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 163 ТАХ-нд 2024 онд 9,432.5 сая төгрөгийн санхүүжилт олгохоос 160 ТАХ-нд 8,144.4 сая төгрөг олгосон нь нийт санхүүжих дүнгийн 84.7 хувийг нь эзэлж байна.

Хүснэгт №05 Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар олгосон санхүүжилт

(сая төгрөг)

⁹ Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах

Хөрөнгийн эх үүсвэр	2024 оны 262-р тогтоолоор				Гэрээний дүн		Олгосон санхүүжилт		
	TAX тоо	Төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн						
			Дүн	Хувь	TAX тоо	Дүн	TAX тоо	Дүн	Хувь
ОНХО	186	10,547.6	9,432.5	89.4	163	9,618.0	160	8,144.4	84.7

Эх сурвалж: Аудитын судалгаа

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хэрэгжсэн 9,618.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 163 төсөл арга хэмжээнд санхүүжилт олгохоос 160 төсөл арга хэмжээний 8,144.4 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.

Тухайн онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 10 ТАХ огт хэрэгжээгүй, хэрэгжиж дууссан 573.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй дараах 16 ТАХ-ний гүйцэтгэлийг жилийн эцэст Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн боловч орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө тасарснаас санхүүжилт олгогдоогүй байна. Үүнд:

- Өлгий сумын 1-60 айлын орон сууцны гадна хүүхдийн тоглоомын талбай барих ажил гэрээний дүн 59.7 сая төгрөг
- Өлгий сумын 4-36 айлын орон сууцны хүүхдийн тоглоомын талбай барих гэрээний дүн 58.9 сая төгрөг
- Бугат сумын төвд хүүхдийн тоглоомын талбай барих гэрээний дүн 58.9 сая төгрөг
- Сагсай сумын Ерөнхий боловсролын сургуулийн камержуулалт гэрээний дүн 15.0 сая төгрөг
- Өлгий сумын 12 дугаар багт гүний худаг гаргах гэрээний дүн 35.0 сая төгрөг
- Өлгий сумын 9 дүгээр багийн захын гудамжинд гүний худаг гаргах гэрээний дүн 20.0 сая төгрөг
- Өлгий сумын хоёр уулзварт гэрлийн дохио тавих(гэрээний дүн 68,8 сая төгрөг
- Мал эмнэлэгийн газарт тавилга худалдан авах гэрээний дүн 15.0 сая төгрөг
- Хогийн сав худалдан авах гэрээний дүн 48.7 сая төгрөг
- Улсын Их Хурлын сонгуулийн санал авах байрны гадна хяналтын камер нийлүүлэх гэрээний дүн 36.0 сая төгрөг
- Баяннуур сумын гүний худгийн цахилгаан мотор худалдан авах гэрээний дүн 10.0 сая төгрөг
- Өлгий сумын 4 дүгээр цэцэрлэгийн халаалтын засвар гэрээний дүн 19.0 сая төгрөг
- Буянт сумын цэцэрлэгийн засвар гэрээний дүн 20.0 сая төгрөг
- Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн засвар гэрээний дүн 29.2 сая төгрөг
- Ногооннуур сумын Эрүүл мэндийн төвийн засвар гэрээний дүн 20.0 сая төгрөг
- Нэгдсэн эмнэлгийн сэргээн засах тасгийн засвар гэрээний дүн 59.6 сая төгрөг

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ТАХ-г гүйцэтгэсэн компанитай гэрээ байгуулж зураг төсөв хийсэн, зохиогчийн болон захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн хуулийн этгээдүүдэд олгох санхүүжилтийг бүрэн олгосон эсэхийг түүвэрлэн шалгахад 47 ТАХ-тэй холбоотой 24.7 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна. (Хавсралт №03)

Дээрх зөрчил нь хяналтыг хэрэгжүүлсэн аж ахуйн нэгжүүд Санхүү, төрийн сангийн хэлтэстэй тухай бүрт нь тооцоо нийлж ажиллаагүйтэй холбоотой байна.

Аудитаар орон нутгийн орлого бүрдээгүйгээс тухайн онд олгоогүй болон дутуу олгосон зураг төсөв, зохиогчийн хяналт болон барилга захиалагчийн хяналтын санхүүжилтийг тооцоо нийлж дуусгахыг Санхүү, төрийн сангийн хэлтэст зөвлөмж болгов.

В.3. Хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг ашиглагч байгууллагууд бүртгэлд авсан байна

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр 2024 онд шинээр болон он дамжин хэрэгжсэн 7,846.5 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 168 ТАХ-г эрх бүхий байгууллагуудын шийдвэрээр (захирамж, тушаал) томилогдсон комисс тухай бүрт нь акт үйлдэж холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгсөн байна.

Дээрх хүлээлгэж өгсөн төсөл арга хэмжээнээс 7,717.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 163 ТАХ-ний үр дүнгээр бий болсон хөрөнгийг холбогдох байгууллагууд орлого авч, данс бүртгэлд тусгасан байна.

Харин дараах 129.5 сая төгрөгийн ТАХ-г урсгал зардлын шинжтэй хөрөнгө гэж үзэн тухайн байгууллага данс бүртгэлд тусгаагүй байна. Үүнд:

- "Монголд зочлох жил" хөтөлбөрт зарцуулсан 60.7 сая төгрөгийн хөрөнгө урсгал зардлын шинж чанартай тул бүртгэх боломжгүй.
- ГИХГ-ын БӨ аймаг дахь хэлтсийн Цагааннуурын авто замын боомтын албан хаагчдын орон сууцны 19.9 сая төгрөгийн халаалтын засварын ажил
- Цахилгаан шугам сүлжээний газрын хуучин дизелийн байран дахь тосны өрөөг диспетчерийн байр болгон засварлах 19.9 сая төгрөгийн ажил
- Алтай сумын ЕБ-ын сургуулийн хуучин дотуур байрны дээвэр, шал болон хаалгыг будах 9.0 сая төгрөгийн ажил
- Ногооннуур сумын Ямаат багийн 20.0 сая төгрөгийн худгийн засвар

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- 1.Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.
- 2.Хөрөнгө оруулалтын 67 хувийг урсгал зардлын шинжтэй, төсөвт өртөг бага төсөл, арга хэмжээнд төлөвлөсөн байна.
- 3.Тендер шалгаруулалттай холбоотой маргаан төсөл арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй байхад нөлөөлсөн байна.
- 4.Төсөл, арга хэмжээний 87.6 хувь нь хэрэгжиж, гүйцэтгэлийн санхүүжилтийн 84.7 хувийг олгосон байна

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

I.Аймгийн Засаг дарга /Е.Зангар/-д:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг тэргүүлэх ач холбогдолтой, хэрэгцээ шаардлагатай, бүтээн байгуулалтын ажлуудыг төлөвлөхөд анхаарах;
2. Зураг төсөв, техникийн тодорхойлолтгүй, эрэмбэлэгдээгүй, урсгал зардлын шинжтэй, тухайн шатны төсвийн өмчлөлд шилжих боломжгүй ТАХ-г төлөвлөгөөнд тусгахгүй байх;
3. Гэрээнд заасан хугацаанд дуусгаагүй, удаашралтай, ашиглалтад авах боломжгүй болсон ТАХ-д дүгнэлт хийж шийдэрлэх, захиалагчийн хяналтыг сайжруулах;

II. Санхүү, төрийн сангийн хэлтэс /Б.Ансаган/-т:

1. Зураг төсөв, зохиогч, захиалагчийн хяналтын болон гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдтэй тооцоо нийлж дуусгах;

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5-т заасан хугацаанд буюу аудитын тайланг хүлээн авснаас 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

ЦАХИМ ДЭЛГҮҮРЭЭС ХУДАЛДАН АВАЛТ ХИЙСЭН ЭСЭХ СУДАЛГАА

Хавсралт №01

/сая.төгрөг/

№	Аймаг, сумын нэр	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Цахим дэлгүүрээс нийлүүлэх боломжтой тоног төхөөрөмж	Эрх шилжүүлсэн засаг даргын захирамжийн дугаар
1	Баян-Өлгий, Өлгий сум	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын гадна камержуулалт, цахимжуулалт хийх	20.0	14.4	A/01
2	Баян-Өлгий, Ногооннуур сум	Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 6 настаны нэг кабинетыг тохижуулах	19.8	6.6	эрх шилжээгүй
3	Баян-Өлгий, Дэлүүн сум	Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвийн үдийн угтах хэсгийн тохижилт	19.8	8.1	эрх шилжээгүй
4	Баян-Өлгий, Өлгий сум	Татварын хэлтэст тавилга тоног төхөөрөмж худалдан авах	55.0	13.8	эрх шилжээгүй
5	Баян-Өлгий, Өлгий сум	Онцгой байдлын газарт тоног төхөөрөмж худалдан авах	17.5	17.5	A/01
6	Баян-Өлгий, Өлгий сум	Цагдаагийн газарт тоног төхөөрөмж худалдан авах	19.0	15.4	A/01
7	Баян-Өлгий, Өлгий сум	Шүүхийн шинжилгээний албанд тоног төхөөрөмж худалдан авах	18.0	11.2	A/01
8	Баян-Өлгий, Өлгий сум	Олон нийтийн радио телевизийн тоног төхөөрөмж худалдан авах	15.0	15.0	A/01
9	Баян-Өлгий, Өлгий сум	Архивын тасагт тоног төхөөрөмж худалдан авах	20.0	17.3	эрх шилжээгүй
10	Баян-Өлгий, Өлгий сум	Шүүхийн тамгын газарт тоног төхөөрөмж худалдан авах	10.0	10.0	A/01
11	Баян-Өлгий, Цагааннуур тосгон	Хилийн цэргийн 0285 дугаар ангид LED дэлгэц, Соёлын төвд тоног төхөөрөмж худалдан авах	20.0	15.0	A/01
12	Баян-Өлгий, Өлгий сум	Хүнс, хөдөө аж ахуйн газарт тавилга, тоног төхөөрөмж худалдан авах	15.0	8.0	A/01
13	Баян-Өлгий, Өлгий сум	ХГБХХГ азарт тоног төхөөрөмж худалдан авах	20.0	13.9	A/01
14	Баян-Өлгий, Цагааннуур тосгон	Цагааннуур боомтод 2 ширхэг ухаалаг дэлгэц худалдан авах	15.0	15.0	1/01/1113
15	Баян-Өлгий, Толбо сум	Толбо Ерөнхий боловсролын сургуульд ухаалаг дэлгэц, шалгалтын тест шалгах төхөөрөмж худалдан авах	17.0	17.0	эрх шилжээгүй
16	Баян-Өлгий, Өлгий сум	Дотоодын цэргийн 829 дүгээр тусгай салбарт тоног төхөөрөмж худалдан авах	19.8	16.0	1/01/1113
17	Баян-Өлгий, Сагсай сум	Сагсай сумын Эрүүл мэндийн төвд хатуу, зөөлөн эдлэл, тоног төхөөрөмж худалдан авах	19.0	4.5	эрх шилжээгүй
18	Баян-Өлгий, Өлгий сум	Нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасгийн эд хогшил худалдан авах	19.0	8.7	эрх шилжээгүй
19	Баян-Өлгий, Өлгий сум	Монгол-Алтай хадны зургийн цогцолборын Хамгаалалтын захиргааны ажилчдыг унаажуулах, тоног төхөөрөмж	15.0	3.8	A/01
		НИЙТ ДҮН	373.9	231.2	

Захиалагчийн хяналтын судалгаа				Хэвсрэлт №02
№	Сумын нэр	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний ангилал*	БЗХяанлт хийсэн эсэх /Тийм,үгүй/
1	Өлгий сум	Номын сангийн ариун цэврийн өрөөг засах	их засвар, тохижилт	үгүй
2	Өлгий сум	ГИХГ-ын БӨ аймаг дахь хэлтсийн Цагааннуурын авто замын боомтын албан хаагчдын орон сууцны халаалтын засварын ажил	их засвар, тохижилт	үгүй
3	Өлгий сум	Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын барилгын засвар	их засвар, тохижилт	үгүй
4	Цагааннуур тосгон	Хилийн цэргийн 0285-р ангийн ажилчидад байр барих	барилга байгууламж	үгүй
5	Өлгий сум	Автотээврийн төвийн засвар	их засвар, тохижилт	үгүй
6	Өлгий сум	Боловсрол шинжлэх ухааны газрын зарим өрөөнүүдэд цонх, салхивч солих	их засвар, тохижилт	үгүй
7	Өлгий сум	Ус цаг уур орчны шинжилгээний төвийн засвар	их засвар, тохижилт	үгүй
8	Цагааннуур тосгон	Цэргийн 0285 дугаар ангид халаалтын шугам татах	барилга байгууламж	үгүй
9	Өлгий сум	Зоонозын төв байрны цахилгаан татах	барилга байгууламж	үгүй
10	Алтай сум	Алтай сумын Ерөнхий боловсролын сургуулийн хуучин дотуур байрны дээвэр, шал болон хаалгыг будах	их засвар, тохижилт	үгүй
11	Баяннуур сум	Баяннуур сумын Цагаан арал багийн зарим айл өрхүүдийг цахилгаанд холбох	барилга байгууламж	үгүй
12	Булган сум	Булган сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн гал тогооны дээврийг шинэчлэх	их засвар, тохижилт	тийм
13	Өлгий сум	Аймгийн Радио телевизийн сүлжээний газрын хоёр цамхагт засвар хийх	их засвар, тохижилт	үгүй
14	Өлгий сум	Өлгий сумын 5 дугаар багт байрлалтай гаалийн албан хаагчдын 4 айлын орон сууцыг засварлах	их засвар, тохижилт	үгүй
15	Сагсай сум	Сагсай эрүүл мэндийн халаалтийн засварын санхүүжилт	их засвар, тохижилт	үгүй
16	Алтай сум	Алтай сумын ЕБ-ын 1-р сургуулийн спорт заалны засвар	их засвар, тохижилт	үгүй

Зураг төсөв, хяналтын зардлын санхүүжилтийн судалгаа			
№	Төсөл арга хэмжээний нэр	Гэрээний дүн	Хавсралт №03
			Нийт олгосон санхүүжилт
1	Номын сангийн ариун цэврийн өрөөг засах	16.0	15.8
2	ГИХ-ын БӨ аймаг дахь хэлтсийн Цагааннуурын авто замын боомтын албан хаагчдын орон сууцны халаалтын засварын ажил	19.9	19.6
3	Автотээврийн төвийн засвар	18.0	17.7
4	Ус цаг уур орчны шинжилгээний төвийн засвар	15.0	14.8
5	4 цэцэрлэгийг камержуулах	19.9	19.7
6	Ногоон байгууламжийн хашаа татах /Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль/	20.0	19.7
7	Зоонозын төв байрны цахилгаан татах	19.0	18.3
8	МАНТХГ-ын хамгаалалтын захиргаанд хяналтын постын түр байр худалдаж авах	18.0	17.7
9	Цагааннуур боомтын орох гарцад нийтийн бие засах газар барих-тендер хуваасан	20.0	19.7
10	Цагааннуур боомтын гарах гарцад нийтийн бие засах газар барих-тендер хуваасан	20.0	19.7
11	Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн камержуулалт	19.5	19.2
12	Өлгий сумын 2 дугаар цэцэрлэгийн засварын дутуу санхүүжилт	9.5	9.2
13	Төрөх тасагийн ариун цэврийн өрөөний засвар	15.0	14.5
14	Өлгий сумын 7 дугаар сургуулийн дотор засвар	20.0	19.6
15	Алтай сумын ЕБ-ын сургуулийн хуучин дотуур байрны дээвэр, шал болон хаалгыг будах	9.0	8.6
16	Булган сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн гал тогооны дээврийг шинэчлэх	18.0	17.7
17	Аймгийн Радио телевизийн сүлжээний газрын хоёр цамхагт засвар хийх	12.0	11.9
18	Өлгий сумын 5 дугаар багт байрлалтай гаалийн албан хагчдын 4 айлын орон сууцыг засварлах	20.0	19.7
19	Сагсай эрүүл мэндийн халаалтийн засварын санхүүжилт	20.0	19.7
20	Өлгий сумын стадионд гүний худаг гаргах	20.0	19.7
21	Өлгий сумын хүүхдийн паркад гүний худаг гаргах	20.0	19.7
22	Өлгий сумын 3 дугаар багт гүний худаг гаргах	35.0	34.5
23	Өлгий сумын 10 дугаар багт гүний худаг гаргах	19.8	19.5
24	Өлгий сумын 13 дугаар багт гүний худаг гаргах	20.0	19.7
25	Цагааннуур тосгонд гэрэлтүүлэг тавих	79.5	78.1
26	Өлгий сумын 1 дүгээр багийн гэрэлтүүлэг тавих /11ш гэрлийн шон/	15.0	14.8
27	Өлгий сумын 8-р багийн 1 дүгээр хэсэг Бүргэдчин гудамжны гэрэлтүүлэг тавих /нарны цэнгээр/	19.8	19.5
28	Өлгий сумын 12 дугаар багт гэрэлтүүлэг тавих	18.0	17.7
29	Өлгий сумын 2 дугаар багт гэрэлтүүлэг тавих	19.8	19.5
30	Өлгий сумын 4 дүгээр багт гэрэлтүүлэг тавих	19.8	19.5
31	Өлгий сумын хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн бохирын шугамын их засвар	12.6	12.2
32	Цагааннуур тосгоны дотуур байрны засвар	85.0	84.9
33	Толбо сумын Эрүүл мэндийн төвийн засвар	59.8	59.6
34	Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн засвар	96.0	94.5
35	Өлгий сумын ЕБ-ын лаборатори 3-р сургуулийн цонх солих засварын ажил	96.1	92.3
36	Өлгий сумын 2 дугаар цэцэрлэгийн засварын ажил	49.7	48.8
37	Булган сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулийн хичээлийн байрны дээврийг сольж, шинээр дээвэрлэх	76.1	74.8
38	Булган сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулд халаалтын зуух тавих	20.0	19.7
39	Өлгий сумын 1 дүгээр цэцэрлэгийн гадна талбайн тохижилт	20.0	19.7
40	Баяннуур сумын 1 дүгээр багийн бага сургуулийн засвар	20.0	19.9
41	Баяннуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр сургуулийн цонх солих	20.0	19.6
42	Баяннуур сумын 1 дүгээр багийн бага сургуулийн дотуур байрны засвар	29.6	28.1
43	Баяннуур сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулийн гадна биеийн тамирын талбайн засвар	39.1	38.4
44	Сагсай сумын ЕБС-ийн 1 дүгээр сургуулийн хичээлийн байрны хаалга, цонх солих ажил	95.0	93.3
45	Бугат сумын Эрүүл мэндийн төвийн засвар	20.0	19.6
46	Цагааннуур тосгоны Соёлын төвийн засвар	6.0	5.9
47	Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн зарим танхимын засвар	20.0	19.7
НИЙТ ДҮН		1,380.5	1,355.80



2025 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/16

Өлгий

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын хавсралтын 18 дугаар хэсгийн 18.9, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны "Эрх шилжүүлэх тухай" А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1-ийн 1.1, 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт" сэдвээр хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг 1 дүгээр хавсралтаар, албан шаардлагыг 2 дугаар баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Нийслэл дэх төрийн аудитын газар, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

3.Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг заасан хугацаанд ирүүлэхийг аймгийн Засаг дарга (Е.Зангар)-т зөвлөсүгэй.

4.Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 7 хоногт багтаан аудитын тайлан болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэж өгөхийг ахлах аудитор (У.Ербол)-д үүрэг болгосугай.

5.Аудитын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор (У.Ербол)-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Х.Женисбек)-т тус тус даалгасугай.



ЖАЙГҮЛ



МОНГОЛ УЛС
БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас: (976) 7042-2483, Факс: (976) 7042-3603
Цахим шуудан: info@bo.gov.mn
Цахим хаяг: <http://www.bayan-olgi.gov.mn/>

2025.05.05 № 1-01/805
танай _____ -ны № _____ -т

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө
оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт
аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Ямар нэгэн санал байхгүй болно.

ЗАСАГ ДАРГА



Е.ЗАНГАР

8325051079



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас: (976) 7042-2483, Факс: (976) 7042-2483
Цахим шуудан: info@bo.gov.mn
Цахим хаяг: http://bayan-olgi.gov.mn/

дод. 5. 05.25 № 5-03/531
танай _____ -ны № _____ - т

**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн сэдэвт аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа, бидний зүгээс ямар нэгэн санал байхгүй болно.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА _____ ДАНСАГАН



8325091154